



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн газрын байр, Сариг баг,
Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23119
Утас: 7036 2553, Цахим хуудас: mohs.khe.gov.mn
Цахим шуудан: eruulmendgazar@khe.monhs.gov.mn

2023.05.22

№ 10-34-02/128/15

“ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭЛЭН”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХЖАРГАЛ
ТАНАА

Барилгын зураг төсөлд хяналт
хийсэн тухай

“Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-ийн боловсруулсан барилгын ажлын зурагт Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 4.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүрэм”-г тус тус үндэслэн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 2-р багийн нутаг дэвсгэрт баригдах “Монголросцветмет ТӨҮГ-ийн 36 айлын орон сууц”-ны барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн зориулалт:

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 2-р багийн нутаг дэвсгэрт баригдах 36 айлын орон сууц нь тэнхлэгээрээ 55.4x11.4м хэмжээтэй, зоорьтой, 3 дахвар, 3 орцтой орон сууцны зориулалттай угсармал хавтгайлжин бүтээцтэй байхаар төлөвлөсөн.

Зоорийн давхарт техникийн өрөө, цахилгааны өрөө, агуулах болон нөөц өрөөнүүд байна.

Тус байгууламжийн халаалтын систем, цэвэр усны систем нь Бор-Өндөр сумын төвлөрсөн системд холбогдоно. Бохир усыг 3 орц бүрээс өөрийн урсгалаар зайлуулан үзлэгийн худгуудад нийлүүлэхээр тооцсон байна. Агаар сэлгэлт нь ердийн систем, барилгын гэрэлтүүлэгийг техникийн өрөө, ариун цэврийн өрөө, гражид ус чийгнээс хамгаалагдсан гэрэлтүүлэг бусад өрөөнүүдэд өрөөний зориулалт, таазны хийцлэлээс нь хамааруулж гэрэлтүүлэгчийг төлөвлөсөн байна. Зургийн ЕГ Шифр ХТХ-03/2023

Хоёр. Захиалагчийн нэр хэзээ, хаана баригдах:

Монголросцветмет ТӨҮГ-ийн захиалгаар Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 2-р багийн нутаг дэвсгэрт баригдана. Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-ийн архитектур Ө.Тимур боловсруулж, захирал Н.Энхжаргал гарын үсэг зурсан. Зургийн ЕГ Шифр ХТХ-03/2023

Гурав: Инженер геологийн судалгааны талаар:

Тус барилгын инженер-геологийн судалгааг “Монголросцветмет ТӨҮГ-ийн” ХХК-ийн захиалга, даалгаврыг үндэслэн “Инженер-геодези” ХХК-ийн боловсруулсан архив №22/98 тоот инженер геологийн дүгнэлтийг үндэслэн төлөвлөсөн. Дүгнэлтээр барилгын талбайд хөрсний ус илрээгүй ба дунд зэргийн төвөгтэй нөхцөлд оршиж байна.

340100028

Дөрөв: Дүгнэлт

4.1. Тус барилгын ажлын зураг төсөл нь Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10 болон бусад аюулгүйн техникийн норм, стандартын шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

4.2. Энгийн хог хаягдалыг түр хадгалах цэгийг ноёлох салхины дор байхаар зохион байгуулах

4.3 Зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлага гарвал Эрүүл мэндийн газрын холбогдох улсын байцаагчид мэдэгдэх шаардлагатай.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Б.МЯГМАРСҮРЭН

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:
ЗАХИРАЛ

Н.ЭНХЖАРГАЛ

